

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Г.Даваадорж

ДХИС-ийн Магистрант, ахлах дэслэгч

galbadrahdavaadorj@gmail.com

Хураангуй: Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн түүхийн урт хугацаанд хоол, тэжээл, бусад хэрэгцээт зүйлээ хадгалж хуримтлуулан удаан хугацаагаар хэрэгцээндээ тааруулан ашиглаж ирснээр нөөцийн тухай ойлголт гарч ирсэн билээ.

Эзэнт гүрэн үүссэн үеэс дайн байлдаанд оролцох, улс гэрээ хамгаалах, жин тээх үед урт хугацаагаар хадгалалт даах борц, ааруул, цай, тос зэргийг бэлтгэн хүн тус бүрт тодорхой хэмжээ тогтоон авч явдаг байсан.

Мөн хааны торгон сүрэг гэж тусад нь үржүүлж төрийн хэрэгт түлхүү ашиглаж ирсэн нь түүхийн зарим нэг сурвалжаас харагддаг. Үүнээс үзэхэд Монголд нөөцийн тухай ойлголт аль эртнээс бий болж, улс оронд тодорхой түүхэн үүргийг гүйцэтгэж гэж үзэх үндэслэлтэй юм.

Ард түмний дунд ч “Үрээ идэхээс үрээгээ ид”, “Айлаас эрэхээр авдраа уудал” гэдэг эрхэм сургаал нь нөөц бүрдүүлэх нь хүний амьдралд зайлшгүй зүйл болохыг гэрчилж байна.

Түлхүүр үгс: нөөц, хүнс, үүц, сан хөмрөг, эдийн засаг

Үндэслэл

Улс орны оршин тогтнох, үндэсний аюулгүй байдлыг хангах нэг гол хүчин зүйл нь эдийн засгийн хараат бус байдал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, бүтээн

байгуулах чиг хандлагатай байна” гэж заасан.

Хөрш хоёр орны зах зээлээс хараат байдалтай, дэд бүтцийн хөгжил харьцангуй сул, хүн амын дийлэнх нь байгаль цаг уурын нөхцөлөөс хамааралтай нүүдлийн аж ахуй эрхлэн амьдардаг, дэлхийн зах зээлийн экспортын цөөн нэр төрлийн барааны үнийн өөрчлөлтөөс эдийн засаг нь хамаарч байдаг, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл сул манай орны хувьд улсын нөөцийн бараа, материалыг хуримтлуулан удаан хугацаатайгаар агуулахын аж ахуйд хадгалах шаардлага зүй ёсоор байсаар байна.

Нэг. Монголчуудын нөөцөө бэлтгэж ирсэн нэн эртний түүхэн эх сурвалжууд

НТӨ 119 онд Тяньянь уулын дэргэдэх Чжаосинь сууринд хятадын хүннүгийн нөөц будаагаар хооллоод үлдсэнийг нь шатаасан, НТӨ 100 онд хятадын Су У-г будааны нүхэн зооринд хорьж байсан, НТӨ 80 онд хүннүгийн тариа боловсроогүй, Тан улсын тайлбарлагч Янь Ши Гу /581-645/ тэд хар будаа тарьдаг гэх зэрэг сурвалжийн чанартай мэдээнээс үзэхэд тэдний тариалан гол төлөв Орхон, Хэрлэн зэрэг том голын хөндийгөөр байжээ. Өөр нэгэн эх сурвалжид дайн байлдааны үед монголчуудын “үр тарианы нөөцийг устган”¹ дуусгасан тухай өгүүлдэг.

Тэгэхээр Монгол орны тариалангийн уламжлал бүр хүннүгийн үеэс улбаатай бөгөөд энэ үед будааны нөөц бүрдүүлэн ашиглаж байна. Эгийн гол дахь Хүннүгийн үеийн баримт олдворуудаас олдсон нэгэн чухал зүйл бол голынхоо сав газраар үр тариа тариалж байсан тухай баттай нотолгоо юм. Тухайлбал хүннүгийн нэгэн бууцны гэрийн зуух орчмоос талх хийдэг буудайтай /*Triticum aestivum*/ төстэй нүүрсэжсэн улаан тарианы амуу буудай олдсон бол өөр нэгэн бууцны малтлагаас /*Triticum aestivum Hordeum*

¹Ала ад Дин Ата Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, хөрвүүлсэн М.Д Бадамням.Боть1.УБ, 2006.т.139.

sr./ буудайны төрөл гарснаас гадна ямар төрөл болох нь тогтоогдоогүй буудайн ширхэг ч олдсон тохиолдол бий.

Судлаачид археологийн судалгааны үр дүнд Монголд шинэ чулуун зэвсгийн /НТӨ IV-II мянган жил/ үе гэхэд газар тариалан бий болж, байгалийн нөөц баялаг, идшинд хэрэглэж болох хар, шар будаа мэтийн төрөл бүрийн үр, ургамал элбэг байсан нь Монгол нутагт газар тариалан эрт үеэс үүсэн гарч болох бодит нөхцөлийг бүрдүүлсэн гэж үздэг юм².

Амьтныг гаршуулах болсон нь нийтийн хэрэгцээний нөөцийг арвижуулах, хамгаалахын тулд нохойг гэрийн болгох үе шатнаас эхэлсэн нь палеолитын дээд үеийн төгсгөл, мезолитын эхэн буюу 10-15 мянган жилийн өмнөх үед холбогдох бөгөөд мезолитын түүвэрчид цуглуулсан тариа будааны нөөцийг оготноос хамгаалахын тулд муурыг гэрийн болгосон нь анчин нохойг гэршүүлсэнтэй цаг хугацааны хувьд ойролцоо байгаа төдийгүй судлаачдын тооцоогоор ямааг НТӨ VII-VI, хонийг VIII-VI, үхрийг VII-VI, адууг V-IV мянган жилийн дотор тус тус гэрийн болгосноор хүн төрөлхтөн мал аж ахуй хэмээх цогцолбор үйлдвэрлэлийн үндсийг бий болгосон байна³.

Монголын нууц товчоонд “Алунгоо хатан хаврын нэгэн өдөр хонины хатсан мах чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха Хатаги, Бухату Салжи, Боданчар мунхаг таван хөвгүүндээ идүүлээд тэднийг зэрэгцүүлэн суулгаж хүн бүрд нэжгээд мөс /сум буюу нарийн мод/-ийг хугал гэж өгвөл амархан хугачиж орхив” гэсэн нь монголчууд эртнээс борцыг хүнсэндээ хэрэглэж байсны жишээ юм.

Рубрукын тэмдэглэлд “Үхэр юмуу адуу үхэхэд махыг нь борцолдог, тэгэхдээ давсалдаггүй, ямар ч үнэр танар ялгаруулдаггүй. Адууны умсаар гахайныхаас илүү хиам бэлтгэж шинээр иддэг, бусад махыг бол өвөл нөөцөлдөг” гэсэн нь мах хадгалах боловсруулах арга одоог хүртэл шалгарсан сонгомол арга хэвээр үлдсэнийг харуулж харуулж байна⁴.

Хятад сурвалжид өгүүлснээр “Монголчуудын айраг ундаа нь дотроо олон төрөл зүйлтэй бөгөөд эсгэх аргаасаа хамаарч өөр амт үнэртэй төдийгүй гүүний сүүг өдөртөө унаганд хөхүүлдэг, харин орой нь гүүгээ хурааж сааж, гүүний сүүгээ хөхүүрт хадгалж, хэдэн хоног сайтар бүлсний дараа чангарах дээр сая ууна” гэсэн бол италийн жуулчны тэмдэглэлд “Үнээний сүүнээс эхэлж тосыг нь ялгаж аваад сүүг ширгэж дуустал нь буцалган хонины туламд хадгалдаг. Тосыг давсалдаггүй. Сүүг их буцалгадаг болохоор

²Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл, УБ, 2006. т. 39.

³Монгол улсын угсаатны зүй.1 боть. УБ,2012. т. 112.

⁴Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл, УБ, 2006. т. 93.

ээддэггүй. Тосыг өвөл хэрэглэхээр нөөцөлдөг. Тосыг нь авсан сүүг наранд дэлгэж хатаахад чулуу шиг хатуу болно. Түүнийгээ өвөл идэхээр ууталдаг, өвөл саальгүй болох цагт хурууд хэмээн нэрийддэг тэр гашуун аарцыг борвинд агуулж дээрээс нь халуун ус хийж дэвтээн уусч замхартал нь байлгаад сүүний оронд уудаг” зэргээр ааруул хийж, тос хайлж хадгалах, хэрэглэх аргыг тодорхой өгүүлсэн байдаг⁵.

Айрагнаас тосыг нь гараар базан аваад малын олгой, гүзээ, давсаг зэрэгт хурааж нөөцөлдөг.

Гүзээ давсаг зэргийг гар шүүс /шар цагаа/-нд идээлж аваад хатааж эвхэнэ⁶ гэснээс үзэхэд монголчууд эртнээс сүү, цагаан идээг боловсруулан хүнсэндээ хэрэглэх нь элбэг байсан бөгөөд тухайлж нэгэн жишээ татахад үхэр, хонь, ямааны айраг (ундаа), тараг, ингэний ундаа, хонь ямааны цөрмийг чанаж буцалгах, ялангуяа үхэр, бог мал, ингэний ундааг нэрж цагаа гаргаж авна. Мөн гүүний айрагтай бусад малын ундаа, таргыг хольж бэсрэглэн чанаж цагаа бэлтгэх арга ч цөөнгүй. Цагаа нь голдуу шүүж шахаж аарцлан ааруул, хурууд тавьж өвөл хаврын улиралд нөөцөлж идэх хатуу, бүхэл идээний эх бүтээгдэхүүн болдог. Бас айраг (ундаа), таргыг нэрж буцалган ээдэм, цагаан хөөсийг ялгэн авч хоолонд өргөн ашиглахын зэрэгцээ цагааг уух, цагаанд бусад төрлийн идээг хольж цагааны шалхмаг, боз зэрэг амтлаг идээ ундааг хийж уудаг байна⁷.

Хагас зүрх, бөөр, гургалдай, хавтарга, сээр, харцага зэргийг үүцэнд хийж нөөцөлнө. Цагаан сараас хойш үүц задална. Цагаан сараар (битүүнд) хураасан өрмөө задлан тос холино. Тосонд мэхээр, нунтаг эззгий, гурил саахар хийж тос холино. Шар тосыг нь авна. Хонь, үхрийн уураг хурааж мөн цагаан сараар гаргаж⁸ хэрэглэхээс гадна өвөлжөөндөө газар ухаж ааруул, тос дараад (11-3.4) дүгээр сард очиход зоорь нөөцөө задалдаг байна⁹. Монголчууд аарцны хавтага гэж аарцны уутыг хэлнэ. Хавтаганаас шүүсэн аарцыг булангаас хөндлөн зүсэж тавьсныг тэмээн тавгийн хурууд гэж нэрлэдэг. (Вандан засгийн хошуу) Тэмээн тавгийн хуруудны зузаан дөрвөн хуруу зузаан байсан. Эсхүл хавтаганы аарцыг бүтнээр нь тавьж (хурууд

⁵Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад сурвалж бичиг. (Ван Говэй, Хэйда Шилуэ цзяньчэн) УБ, 2005. т. 77.

⁶Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть II. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011. т. 91

⁷Монгол улсын угсаатны зүй. Боть I УБ, 2012, т. 127-128.

⁸Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть V. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011. т. 284.

⁹Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть V. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011. т. 286.

ааруул) нөөцөлнө¹⁰. Тэрчлэн нэг жилд нөөцөлж авсан ааруул, хурсыг дахиад ааруул, хурс хийх цаг болтол идэж хэрэглэдэг. Эзэгийг удаан хадгалдаггүй байна¹¹. Судлаачдын бүтээлд көншилэмэл гэдгийг (хатаасан мах) гэж орчуулсныг эрдэмтэд голдуу баримтлан “хатсан мах”, “хуршсан мах”, “хуршиж хагссан мах” гэх зэргээр ерөнхийдөө ойролцоо утгатай үгээр буулгажээ. Харин уг үгийн гарлын хувьд гэвэл энэ нь якут хэлний көнсү буюу хол юманд авч явахаар бэлтгэсэн хүнсний нэртэй холбоотой байж магадгүй юм. Якут хэлний “көнсү” нь утгаа монгол бичгийн хэлний “күнсү” (хүнс) гэдэгтэй гарал нэгтэй билээ. Дорнод аймгийн буриад ястны ардын аман зохиолд үхрийн борцыг “көнжү” гэж хэлэх тохиолдол гарч байсан байна. Монголын нууц товчооны “көншилэмэл хонин” гэдэг бол хиншүүлж утах юм уу борцлох аргаар удаан хадгалахад зориулж бэлтгэсэн нөөц махыг нэрлэжээ. Ойрадын зарим аялгуунд “хиншүү” гэхийг “көнсүү”, “киншүү” гэдэг байна¹².

Ляо улсын түүхэн бичигт Хятан нарын заншил бол адуу мал нь өвс, усыг дагаж бэлчээрлэх, хүн нь сүү саалинд түшиглэж, мэргэн харвах явдлаар амьдарлага болгодог, малаас гарах ашиг шимийг эрхэмд үзэж түшиглэдэг байсан тухай дурддаг бөгөөд монголчууд өнөөг хүртэл малын махыг өвөл, намар нь борцолж хатаагаад хавар хүнс цагаан идээ тарчиг үед гаргаж хэрэглэдэг ба энэ уламжлал бүр эрт үед ч байсан болно.

Монголчууд холын аянд явах, улс орныг нэгтгэх дайн байлдаанд явахад хүнсийг муудахаас хамгаалах, аюулгүй хадгалах явдал байв. Хатаах, давслах, боловсруулж хадгалах зэрэг олон аргуудыг хэрэглэдэг байсан нь түүхээс харагдаж байна.

Хоёр. Монгол улсын нөөцийн сан хөмрөг бүрдэж эхэлсэн он жилүүдийн түүхэн эх сурвалжууд

Монгол Улс XX зууны эхэнд амиа аргацаасан мал аж ахуйтай, өөрийн гэх үйлдвэр, олигтой худалдаа, үндэсний мөнгөн тэмдэгт байхгүй, эдийн засаг нь уналтад орсон, мэргэжилтэй ажилтан нараар дутмаг байснаас улс орныг өөд татах, санхүүгийн үндэсний системийг бий болгох хүнд зорилт тулгарсан юм.

Улсын сан хөмрөгийг арвижуулахад бололцоотой бүхий л нөөц боломжийг ашиглахыг урьтал болгон ажиллаж байсан бөгөөд юуны өмнө бүх төрлийн татвар, хураамжид, тэр тусмаа уул уурхай, газар доорх баялаг,

¹⁰Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть IV. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011. т. 294.

¹¹Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть X. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011. т. 169.

¹²Д.Цэрэнсодном. Нууц товчооны оруулга, тайлбар. УБ, 2002. т. 197

ашигт малтмал эрдэнэсийн зүйл болоод дотоод гадаадын хураамжид ихээхэн анхаарал хандуулж байсан нь судалгаагаар харагдаж байна¹³.

XX зуунд дэлхийн I, II дайн, халхын голын дайн зэрэг томоохон улс төрийн үйл явдлууд болж байсан бөгөөд энэ нь дэлхийн том улс гүрнүүд газар нутгаа өргөтгөх бодлого явагдан дэлхийд капиталист социалист гэсэн хоёр үзэл бодолд хуваагдан, “хүйтэн” дайны үе байсан нөхцөлд улс орнууд тусгаар тогтнолоо хамгаалах “цөмийн дайн” –д бэлтгэх асуудал хурцаар тавигдаж улмаар улс орнууд “материаллаг нөөц” бүрдүүлэх асуудалд анхаарч эхэлсэн байна. Дэлхийн улс төрийн уг бодлого Монгол Улсын эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд ихээхэн саад тотгор учруулж байсан бөгөөд манай улсын хувьд гол төлөв цэргийн дайчилгааны нөөцтэй байсан байна. Баримтаас үзэхэд цэргийн хүнс, хувцас, эмээл, хазаар, зэр зэвсэг, агт морь, цэргийн агтны өвс зэргийг улсын сангаас Цэргийн яаманд гаргаж байсан байна. 1923 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөл, Бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Мал тариалангийн яам байгуулагдаж түүний харьяанд “Улсын үл халдах фонд” буй болсон байна.

Байгалийн эрс тэс уур амьсгалтай манай оронд ган, зудын гамшигт өртөн мал олноор үхэж үрэгдэх явдал удаа дараалан тохиолдож байв. Тухайлбал 1934-1935, 1938 онд учирсан байгалийн бэрхшээлд их хэмжээний мал хорогджээ. Иймээс малын хорогдлыг бууруулах олон талын арга хэмжээ авсны нэг нь хадлан тэжээл бэлтгэн нөөцөлж өвөл, хавар хэрэглэх асуудал байв. Зөвлөлт Холбоот Улсын тусламжаар байгуулагдсан өвс хадах станцууд нь хувийн аж ахуйтнуудын өвс тэжээл бэлтгэхэд ихээхэн дэмжлэг үзүүлсэн бөгөөд 1939 онд машин трактороор өвс хадах станцын ажлыг сайжруулж, тэдгээрийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэх талаар төр засгаас тодорхой хэмжээний арга хэмжээ авч, станцуудын хадсан өвсийг бараа таваарын нэгэн адил үзэж тэжээл хэрэгцээтэй аймгуудад тээвэрлүүлж борлуулж байх тээврийн зардлыг хэмнэх зэрэг шийдвэр гаргасан байна.

Тэрчлэн эдгээр станцууд бол ганц ардын малыг өвс тэжээлээр хангаж ган, зуд гачгаас хамгаалах төдий бус, өөрийн малыг үлгэр жишээчээр үржүүлэх, өсгөх, тариа ногоо тарих ажлыг дэлгэрүүлбэл зохих газар болно¹⁴ гэж үзэж байв.

Монгол Ардын Хувьсгалт Намын 1940 оны X дугаар их хурлаар Мал аж ахуйн тэжээлийн бааз байгуулах шийдвэрийг гаргасан байна. Монгол

¹³З.Лонжид. Түүх сөхөхүй. УБ, 2011. т. 319.

¹⁴Монгол Улс. УТА. Ф.1, д.2. хн. 1034, х. 63.

Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны 1943 оны 2 дугаар сарын 20-25-нд хуралдсан ээлжит бүгд хурлаар улс ардын аж ахуйн төлөвлөгөөний хяналтын тооны тухай асуудлыг хэлэлцсэн байна. Тус хурлаар “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1943 оны аж ахуйн бодлогын үндсэн зорилго бол ард түмэн ба улсын хэрэгцээг хангах явдлыг өргөтгөх ба улс орноо батлан хамгаалах явдлыг цаашид бэхжүүлэх хийгээд түүнчлэн одоогийн олон улсын хоорондын байдлын хүнд үед тохиолдож болох аливаа гэнэтийн явдалд тус улсын эдийн засгийг бэлхэн байлгах үндсэн дээр тус улсын хоол хүнс, бараа таваар, мөнгөн санхүүгийн хүрэлцэх хэмжээний нөөц (резерв) бэлтгэлийг ихээр байгуулах зорилго байх ёстой”¹⁵ гэж тогтоож өгсөн нь улсын нөөц бий болох үндсэн суурь тавигджээ гэж үзэж болохоор байна.

1943 оны 3 дугаар сарын 16-ны өдөр хуралдсан Ардын сайд нарын Зөвлөлийн 17 дугаар хурлын тогтоолд Сайд нарын зөвлөлийн бэлтгэл фонд байгуулж уг фондыг “гэнэтийн аюул буюу өөр онц байдлууд тохиолдсоны улмаас зохих зардлуудыг нөхөх явдалд”, “нийт улсын ба батлан хамгаалах ач холбогдол бүхий үндсэн барилга буюу улс орныг батлан хамгаалах явдал, аж ахуй, соёл боловсролын арга хэмжээнүүдийг биелүүлэх явдалд”¹⁶ зарцуулахаар журамласан байна.

1944 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Ардын сайд нарын Зөвлөл, Намын төв хорооны хамтарсан хурлаар өвсний фонд байгуулах тухай шийдвэр гаргаж 106/75 дугаар тогтоолоор “Нэг. Дотоод яамны аж ахуй ба сангийн трестийн аж ахуйд доор дурдсан хэмжээгээр улсын мэдлийн өвсний фондыг байгуулсугай. Хоёр. Уг фондыг засгийн газрын тусгай зөвшөөрөлгүйгээр зарцуулж үл болно”¹⁷ гэж тогтоосон байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн маш нууц 244 дүгээр тогтоолоор “Өргөн хэрэглээний барааны улсын нөөц байгуулах тухай” үүргийг тухайн үеийн Худалдаа бэлтгэлийн яам, Гадаад худалдааны яамд үүрэг болгосноор Улсын нөөцийн бараа, материал хуримтлуулах түүхэн замнал эхэлсэн байна¹⁸.

БНМАУ-ын Худалдаа бэлтгэлийн яамны 1965 оны 76 тоот тушаалаар улсын байнгын нөөц байгуулахыг хязгаарын дамжлага бааз болох Дорнод, Хөвсгөл, Баян-Өлгий аймгийн дамжлага баазуудад үүрэг болгож, Худалдаа бэлтгэлийн яамны Барааны төв баазад Улсын байнгын хүнсний болон өргөн хэрэглээний нөөцийн бараа болох гурил, шар будаа, цагаан будаа, хуурай

¹⁵“Үнэн” сонин. №31, /2364/, 1943.02.06.

¹⁶“Монгол улс, УТА, х. 1, д.3, хн. 149, хуудас 187-188.

¹⁷“Монгол улс, УТА, х. 1, д.3, хн.219, хуудас 118.

¹⁸Ж.Амарсанаа. Монгол Улсын нөөцийн түүхэн замнал. УБ, 2016 он

сүү, ногоон цай, дүнсэн тамхи, лаа, хөвөн бөс бараа, брезент, бор эсгий зэрэг 29 нэр төрлийн зүйлийг хуримтлуулан хадгалах болжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 229 дүгээр тогтоолоор 9 аймагт Аюулаас хамгаалах өвс тэжээлийн Улсын фондуудыг анхлан байгуулж ажиллуулж байгаад Засгийн газрын 1991 оны 145 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн яамны харьяанд шилжүүлэн Толгойт, Дархан, Чойр, Сэлэнгэ, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Увс зэрэг 14 аймгийн 56 цэгт өргөтгөн зохион байгуулжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 299 дүгээр тогтоолоор Тарианы үрийн улсын нөөц бий болж, нийт 54,0 мянган тонн үр хадгалах хүчин чадалтай салбаруудыг Хөдөө аж ахуйн материал-техникийн хангамжийн удирдах газрын харьяанд байгуулжээ. Үүнд Дархан, Орхон, Угтаал, Жаргалант, Хархорин, Баруунтуруун, Хэрлэн, Тариалан, Түвшрүүлэх, Ингэтолгойн сангийн аж ахуй, Эрдэнэсант, Тэсийн тэжээлийн аж ахуй, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумдууд багтжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 15 дугаар тогтоолоор Улсын аюулаас хамгаалах шатахууны нөөцийг баруун таван аймагт байгуулахаар болж, улмаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 235 дугаар тогтоолоор Тээврийн яамны харьяа Улаанбаатар хот, Сүхбаатар, Ховд, Дорноговь, Өмнөговь аймаг, Чойр, Мандалговьд шатахуун тослогооны материалын улсын нөөц байхаар болсон байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 235 дугаар тогтоолоор Материал Техникийн Хангамжийн улсын хорооны харьяа Материал техникийн хангамжийн 6 ерөнхий газарт материалын үнэт зүйлсийн улсын нөөцийг бий болгожээ. Харин 1987 онд Материал Техникийн Хангамжийн улсын хорооны дэргэд улсын нөөцийн анхны төвлөрсөн бааз болох “Объект №03” байгууллагыг “Дүүрэнбулаг” гэдэг нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 235 дугаар тогтоолоор тухайн үеийн Эрүүлийг хамгаалах яам хариуцан улсын нөөцийн хүний эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, ороох боох материал, ариутгалын бодисыг Улсын эм хангамжийн үйлдвэрийн газар, Баян-Өлгий, Ховд, Дорнод, Өмнөговь, Говь-Алтай аймгуудын эмийн сангуудыг удирдах конторын нөөцийн тасагт бий болгосон байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 235 дугаар тогтоолоор тухайн үеийн Холбооны яам хариуцан холбооны хэрэгсэл, шугам барилга, маркийн улсын нөөц бий болжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 439 дүгээр тогтоолоор Эрчим хүчний үйлдвэрүүдийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор үйлдвэрлэл техникийн барааны улсын нөөц болох “Аваарийн нөөц” байгуулж 198 төрлийн цахилгаан, дулааны тоног төхөөрөмжийг тухайн үеийн Түлш эрчим хүчний яамны харьяа байгууллагууд дээр бүрдүүлж улсын нөөцөд хадгалах болжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1981 оны 28 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Бөөний худалдааны нэгдлийн төв агуулах, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Багануурын бөөний бараа бааз болон, Дорнод, Баян-Өлгийн Цагаан нуур, Хөвсгөлийн Хатгалын гадаад худалдааны дамжлага баазад хүнсний нөөцийн барааг хуримтлуулан хадгалж байжээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 130 дугаар тогтоолоор тухайн үеийн Хөнгөн, хүнсний яамны харьяанд Экспортын барааны улсын нөөц бий болгосон байна. Үүнд: ямааны арьс, хонины арьс, хүрэн шир, шевро, хром, ээрсэн ноосон утас, савхин пиджак, савхин дээл, нэхий дээл, тарваганы арьс, адууны дэл зэрэг экспортын бүтээгдэхүүн оржээ.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1989 оны маш нууц 84 дүгээр тогтоолоор улсын нөөцөд иж бүрэн монгол гэр, 1990 оны маш нууц 13 дугаар тогтоолоор тусгай зориулалтын болон автомашин механизм хуримтлуулах болсон байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын 1991 оны “Үрийн улсын нөөцийн талаар авах арга хэмжээний тухай” 254 дүгээр тогтоолоор Гурил тэжээлийн үйлдвэрээс улсын нөөцийн үр хадгалах 13 салбарыг Таримал ургамлын үрийн хяналтын улсын албанд харьяалуулжээ.

Монгол улсын Засгийн газрын 2002 оны 2 дугаар тогтоолоор стратегийн байршилд 7 агуулах, 8 шатахуун түгээх станцыг улсын нөөцийн шатахуун тослогооны материалын хамт Нефть Импорт Компаниас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газарт шилжүүлэн өгч бие даасан үйл ажиллагаа явуулах болсон байна.

Хөдөө аж ахуйн яамны харьяа Биокомбинат нь малын био бэлдмэл, хуурай болон шингэн вакцинуудын улсын нөөцийг хариуцаж ажилладаг байсан бөгөөд Улсын мал эмнэлгийн албаны төсвөөс санхүүжиж байв.

Гурав. Улсын нөөцийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тушаалаар батлагдсан Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн дагуу ОБЕГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/218 дугаар тушаалаар орон нутгийн Онцгой байдлын газрын бүрэлдэхүүнд Улсын нөөцийн салбарууд нэгтгэгдэж салбарын статустайгаар үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Харин Булган, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймаг дахь Улсын нөөцийн салбаруудыг Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги нэртэйгээр бүтэц, орон тоог өргөтгөөд байна.

Дүгнэлт

Монголчууд бүр Хүннүгийн үеэс эхлэн будааны нөөц бүрдүүлэн ашиглаж байсан нь Эгийн гол дахь Хүннүгийн үеийн баримт олдворуудаар нотлогдож байна.

Нэрт судлаач Рубрукын тэмдэглэлд “Үхэр юм уу адуу үхэхэд махыг нь борцолдог, тэгэхдээ давсалдаггүй, ямар ч үнэр танар ялгаруулдаггүй. Адууны умсаар гахайны махнаас илүү хиам бэлтгэж шинээр иддэг, бусад махыг бол өвөл нөөцөлдөг” гэсэн нь мах хадгалах боловсруулах аргыг Монголчууд нэн эрт үеэс өнөөг хүртэл шалгарсан сонгомол арга хэлбэрээр хойч үедээ өвлөн үлдээснийг нотлон харуулж байна

1960-аад оноос тарианы үрийн улсын нөөц бий болж, нийт 54,0 мянган тонн үр хадгалах хүчин чадалтай салбаруудыг Хөдөө аж ахуйн материал-техникийн хангамжийн удирдах газрын харьяанд байгуулж байсан нь улс орны дотоодын хэрэгцээг бүрэн хангадаг байсныг гэрчилж байгаа явдал юм

Ямааны арьс, хонины арьс, хүрэн шир, шевро, хром, ээрсэн ноосон утас, савхин пиджак, савхин дээл, нэхий дээл, тарваганы арьс, адууны дэл зэрэг экспортын бараа бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлдэг байсан нь валютын нөөц бүрдүүлэх давхар бодлогыг агуулсан байна.

Улсын нөөцийн салбаруудыг орон нутгийн Онцгой байдлын газрын бүрэлдэхүүнд нэгтгэж улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги нэртэйгээр бүтэц, орон тоог өргөтгөсөн нь гамшиг осол, аюулт үзэгдлийн үед аврах, сэргээн босгох, хойшлуулшгүй үйл ажиллагааг цогц хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа болно.

Ашигласан материал

1. Ала ад Дин Ата Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, хөрвүүлсэн М.Д Бадамням.Боть1.УБ, 2006
2. Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл, УБ, 2006
3. Монгол улсын угсаатны зүй.1 боть. УБ,2012
4. Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл. УБ, 2006
5. Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад сурвалж бичиг. (Ван Говэй, Хэйда Шилуэ цзяньчэн) УБ, 2005
6. Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. Боть II. Эрхэлсэн С.Чулуун, УБ, 2011